



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 5/68

Хэрлэн сум

С.Нямдаваад хувийн чөлөө олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.4, 100 дугаар зүйлийн 100.1, 100.2, аймгийн Засаг даргын Тамгын газрын "Дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.11 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Сүрэнгийн Нямдаваагийн гаргасан хүсэлтийн дагуу 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 5 хоногийн хувийн чөлөө олгосугай.

2.Хувийн чөлөөтэй байх хугацааны олговрыг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн (Ш.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНТУЛГА

